1-р улирал, 2017-2018 оны хичээлийн жил

TJMS IB СУРГУУЛИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН СОНИН

“Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа сурах нь”

TJMS нь нийгэмд үйлчлэхэд суралцахыг эрхэмлэдэг.

Нийгэмд үйлчлэж суралцах, сургалтын хөтөлбөр

Нийгэмд үйлчлэхэд суралцах арга барилыг ашиглан сургалтын хөтөлбөрийг заахад сурагчид хичээлийн танхимд сурч байгаа зүйлээ нийгэмд тохиолдож байгаа асуудалтай холбож хамаатуулахад суралцдаг. **Бүх сурагч нийгэмд үйлчлэхэд суралцах процессын дараах таван үе шатаар дамжина. Судлах, бэлтгэх, хэрэгжүүлэх, шүүн тунгаах, биеэр харуулах. Сургуулиас гадуур “бодит амьдралын” хэрэгцээ шаардлагыг хангахын тулд тэд ухагдахуун, ур чадвар, мэдлэгийг ашигладаг.** TJMS-ийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан нийгэмд үйлчлэхэд суралцах үйл явцын нэг жишээ нь гэр бүл, хэрэглээний шинжлэх ухааныг хослуулсан Оёдол, хүүхдийн хөгжлийн бүлэг юм. Сурагчид хүүхдүүдэд тохиолддог тааламжгүй зүйлийн үр дагаврыг судалж, “Надаас бүү ай мангас минь” гэсэн сэдэвтэй хүүхэлдэй хийж, хотын асрамжийн газар хандивласан.

Үргэлжлэл 3-р хуудсанд бий.

Сурагчид олон нийтийн төслийн хүрээнд Пуэрто Рико арлын эмэгтэйчүүдийн хийсэн эд, зүйлсийн дэлгүүрийг ажиллуулсан юм. Тус дэлгүүрийн борлуулалтын орлогыг тус арал дээр болсон далайн шуурганд өртсөн иргэдэд түгээнэ.

Олон нийтийн төсөл

Олон нийтийн төсөл бол сурагчдын бие даан хэрэгжүүлсэн халамжлан үйлчлэхэд суралцах ажиллагааны загвар юм. Энэ жилийн төслүүд хэрэгжиж эхэлсэн бөгөөд сурагчид ганцаараа болон бүлгээр иргэдийн янз бүрийн эрэлт хэрэгцээг хангаж байна. Төслийн сэдэвт цагаач, дүрвэгсдэд туслах, орон гэргүй хүмүүсийг байр сууцаар хангах, өсвөр насныхны нийгмийн болон сэтгэцийн эрүүл мэнд, байгалийн гамшигт өртсөн иргэдэд туслах гэх зэрэг багтаж байна.

TJMS-ийн сурагчдын эцэг эхчүүд нь олон нийтийн төслийн хөрөнгө босгох арга хэмжээ, кампанит аяныг 3-р сарын 2-ны эцэг, эхчүүдийн хурлын үеэр дэмжиж, хандив өгөх боломжтой.

> ***I never perfected an invention***
> ***that I did not think about***
> ***in terms of the service it might give others . . .***
> ***I find out what the world needs,***
> ***then I proceed to invent.***
> *Thomas A. Edison, inventor*

Олон нийтийн төсөл нь сурагчдад дараах боломж олгож, урамшуулан дэмжих зорилготой:

- олон улс даяар тогтвортой, өөрөө санаачилсан судалгаанд оролцох
- шинэ бүтээлч санаа олж, гүн гүнзгий судалгаа хийх замаар улам сайн ойлголттой болох
- удаан хугацаанд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, хандлага, мэдлэг эзэмшиж харуулах
- янз бүрийн нөхцөл байдалд ур дүнтэй мэдээлэх
- суралцах ажиллагаагаар дамжуулж буюу суралцах явцын үр дүнд хариуцлагатай ханддаг болох
- суралцах процессыг мэдрэн ойлгож, гаргасан амжилт бүтээлээрээ бахархах.

Сурагчдын Олон нийтийн төсөл бол сургуульд ашиг тусаа өгөх зорилготой хөрөнгө босгох үйл ажиллагаа юм.

Сурагчид мөн сургуулийн байрны түвшинд халамжийн үйлчилгээнд оролцоно. 6, 7-р ангийнханд IB вэб хуудасны Халамжийн үйлчилгээний хуанлид улирал бүр зарладаг олон боломжийг алдалгүй оролцохыг уриалж байна.

Энэ жил ивээн тэтгэж буй зарим арга хэмжээнд Харви далайн шуурганд өртсөн хохирогчдод хэрэгцээтэй байгаа эд зүйлсийг цуглуулах аян багтаж байна. Цуглуулсан эд зүйлсийг Тексас муж улс уруу тээвэрлэх олон ачааны машинд ачихаар Nationals Stadium-д аваачсан билээ. *Бид мөн Африкийн дугуй гэсэн нэртэй унадаг дугуй цуглуулах аян өрнүүлсэн.*



Энэ жил **10-р сард тусалцгаая** сэдэвт аяны хүрээнд сурагчид, тэдний гэрийнхэн жил тутам зохион байгуулдаг Арлингтоны алхалтын үеэр алхаж 600 гаруй ам.доллар цуглуулах, мөн Culpepper Gardens байгууллагын өндөр настнуудад хоолоор үйлчлэх зэрэг олон үйл ажиллагаанд оролцсон.

Мартин Лутер Кингийн **дурсгалыг хүндэтгэх** амралтын өдөр сурагч, эцэг эхчүүд Арлингтон хотын эмзэг бүлгийн өрхүүдэд зориулан хүнсний бүтээгдэхүүнийг 1000 гаруй торонд хийж баглахад тусалсан.



TJMS-ийн 6, 7-р ангийнхан *Африк тивд дугуй илгээе аяны хүрээнд унадаг дугуй цуглуулах Олон нийтийн төсөлд нэгдэж байна.* 8-р ангийн сурагч төслөө Арлингтон бүсийн Удирдах зөвлөлийн хурал дээр танилцуулсан. Дээрх зураг дээр сурагчид унадаг дугуй цуглуулах аяныг сурталчлах самбар хийж байна. Доорх зураг дээр Африк тивд дугуй илгээе нэртэй байгууллагыг үүсгэн байгуулагчдын нэг Дикис Данкэн хэрхэн дугуй бэлэглэж буй хүмүүстэй мэндчилэх, унадаг дугуй цуглуулах ажилтай холбоотой үүргийг гүйцэтгэх талаар сурагчдад сургалт явуулж байна.

Үйлчлэхэд суралцах, сургалтын хөтөлбөр хэсгийн үргэлжлэл

8-р ангийн англи хэл, дэлхийн газарзүйн багш нар "Усны төсөл" гэсэн нэртэй сонирхолтой, олон салбарыг хамарсан хичээл заахаар хамтран ажилласаар байна. Энэ жил дайжих, дайжсан хүмүүсийн зовлон бэрхшээлийн тухай илүү түлхүү үзэхээр болсон.

"Нийгэмд үйлчлэхэд суралцуулж, туслах үйл ажиллагаанд биечлэн оролцуулах нь сурагчдад аливаа санааг бие даан хэрэгжүүлэх арга барилд суралцуулах нөхцлийг бүрдүүлэх найдвартай загвар болж байна." (ДНХ-өөс: Зарчмыг хэрэгжүүлэхүй, 2017 он)

Болсон явдлын талаар санал сэтгэгдлээ хуваалцахаар хүмүүс ирсэн. Арлингтон хотын дүрвэгсдэд туслах байгууллага болох Этиопын иргэдийн хөгжлийн зөвлөлийн ажилтан Солэс Данкэн дүрвэгчийн статустай болж, дараа нь Америкийн Нэгдсэн Улсад төвхнөхийн тулд хүмүүсийн давж туулах ёстой хүнд хэцүү процессын талаар сурагчдад ярьж сонирхуулсан юм. "734 Кофе" байгууллагын үүсгэн байгуулагч, захирал Манянг Хэр мөн сурагчидтай ярилцсан. Ноён Хэр нь нэгэн цагт сэтгүүлчдийн нэрлэснээр "Суданы төөрсөн жаал" байжээ.

Хэр нь АНУ-д иртлээ дүрвэгсдийг түр байрлуулах газар 16 жил амьдарчээ. Түүний үйлдвэрлэдэг кофег Этиоп улсын Гамбела бүсэд ургуулж, АНУ-д худалддаг. Дүрвэгсдэд "утга учиртай, тусламжаас ангид" амьдрах боломж олгохын тулд борлуулалтын орлогын хорин (20%) хувийг ферм, усаар хангах, дүрвэгсдэд зориулсан мэргэжлийн сургалт зохион байгуулахад зарцуулдаг.

TJMS-ийн нийгмийн үйлчилгээний зорилт

6-р анги

* Үйлчилгээний 2 чиглэл сонгож, ангиас гадуур ядаж нэг халамжийн үйл ажиллагаанд оролцох.
* Сургалтын үр дүнг дүгнэхийн тулд 2 үйл ажиллагааны талаар шүүн тунгаах. (Гарах үр дүнг баруун талд харна уу)
* Халамжийн үйлчилгээний явц, Баталгаажуулах маягт ашиглан үйл ажиллагааг ивээн тэтгэгч байгууллагаар гарын үсэг зуруулах.

7-р анги

* Халамжийн үйлчилгээний 2 чиглэл сонгож, сонирхсон чиглэл бүрд халамжийн үйлчилгээний доод тал нь нэг үйл ажиллагаа оруулж, хамгийн багадаа 3 үйлчилгээний үйл ажиллагаанд оролцох.
* Халамжийн үйлчилгээний хоёр үйл ажиллагааг ангиас гадуур хэрэгжүүлэх ёстой бөгөөд доод тал нь нэг үйл ажиллагааг сургуулиас гадуур хэрэгжүүлэх ёстой.
* IB-ын халамжийн үйлчилгээний үр дүнд хүрэхийн тулд тухайн үйл ажиллагааг шүүн тунгаах. (Гарах үр дүнг баруун талд харна уу)
* Халамжийн үйлчилгээний явц, Баталгаажуулах маягт ашиглан үйл ажиллагааг ивээн тэтгэгчдээр гарын үсэг зуруулах.

8-р анги

* Олон нийтийн төслөөр дамжуулан халамжлан үйлчлэх ажиллагааны шаардлагыг хангана.

Сурагчид хийж дуусгасан бодлын тэмдэглэл, аливаа гэрэл зургийг өөрсдийн дижитал IB хавтсандаа байршуулах хэрэгтэй.

Дэлхий даяарх олон улсын бакалаврын сургуулиудын нийгмийн үйлчилгээнд суралцах явцын үр дүнд сурагчид дараах чадварыг эзэмшинэ:

* *давуу тал, сайжруулах чиглэлээ улам сайн мэдрэх*
* *сурагчдын санаачилсан үйл ажиллагааны талаар ярилцаж, үнэлж, төлөвлөх*
* *шинэ ур чадвар эзэмшихийн тулд хүнд хэцүү даалгавар гүйцэтгэх*
* *махруу зүтгэх*
* *бусадтай хамтарч ажиллах*
* *үйлдлийнхээ ёс зүйн үр дагаврыг харгалзаж үзэх*
* *олон улсад хувь нэмэр оруулах, олон хэлээр ярих, бусад улс орны ёс заншлыг ойлгох замаар олон талын мэдлэгтэй болох*

ТУ-ийн багш үйлчилгээний даалгаврыг хийж дуусгасан эсэхийг баталгаажуулна. ДНХ-ийн зохицуулагч шүүн тунгаах даалгаврыг шалгана.

Халамжийн үйлчилгээний яармаг амжилттай болов

Халамжийн үйлчилгээнд төвлөрсөн жилийг эхлэхдээ бид орон нутгийн халамжийн үйлчилгээний байгууллагуудын эрэлтийг хангахаар сурагч, ажилтнуудад зориулсан жил тутмын Үйлчилгээний яармаг зохион байгуулсан. Орон нутагт, үндэсний хэмжээнд, олон улсад иргэдийн эрэлт хэрэгцээг хангаж ажилладаг 15 гаруй байгууллага оролцсон. Олон нийтийн төсөл, мөн дараах төсөлтэй холбоотойгоор 8-р ангийн хэд хэдэн сурагч оролцсон байгууллагуудтай хамтран ажиллахаар болсон: *Хуудас эргүүлэх, "Африк тивд дугуй илгээе", "Уолтер Рийд 55+" төв, "Өсвөр насныхан тусална" мөн орон нутгийн* амьт ан асрах газар. Тус яармагийн ачаар сургууль даяар явагдах олон арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Дээрх зураг дээр сурагчид халамжийн үйлчилгээний яармагт оролцсон "Culpepper Gardens" настнуудын төвийн тухай мэдээлэл авч байгаа нь. Доорх зураг дээр сурагчид "*Өсвөр насныхан тусална" буюу ӨСТ гэсэн нэртэй Арлингтоны хөтөлбөрийг шугамаар бусад өсвөр насны хүүхдүүдэд туслах боломжийн талаар судалж байна.*

Үйлчилгээний яармагт оролцсон "Зөвхөн тор" байгууллага гадаадын иргэдэд шумуулны тор илгээдэг. Энд TJMS-ийн сурагчид шумуулны торыг сонирхож байна.





Энэ өдрийг тэмдэглэж аваарай!

TJMS IB-ын үзэсгэлэн/ Олон нийтийн төслийн танилцуулга

2018 оны 4-р сарын 17

18:00-19:30

Том санаа сэдлийн талаар судлах, танин мэдэхийг дэмжих, бүтээлч байдлыг хөгжүүлж, сурагчдаа бодож тунгаах, бүтээлч байх, шүүмжлэлтэй хандахад уриалсан үнэлгээ, сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

Мөн **8-р ангийн Олон нийтийн төслүүдийг** танилцуулна. Сурагчид маань хэрхэн манай хот, улс, мөн олон улс орны хүмүүст хувь нэмэр оруулсан талаар олж мэдээрэй.